Нийгмийн эрүүл мэнд судлалч мэргэжилтний цогц чадамжид хийсэн үнэлгээний үр дүн

С.Мягмарчулуун[1], Б.Янжинлхам[2], Д.Отгонбаяр[3], Л.Баярмагнай[1], Э.Эрдэнэчимэг[1], Д.Даваалхам[1], Д.Амарсайхан[1]
[1]Нийгмийн эрүүл мэндийн сургууль, АШУҮИС
[2]НЭМ-ийн магистрант, АШУҮИС
[3]ШУТГ, АШУҮИС
Цахим шуудан: tyagmarchuluun@mnums.edu.mn, Утас:89004748

Түлхүүр үг:

НЭМ судлалч мэргэжилтэн,
хөтөлбөр,
цогц чадамж

Товч утга:

Хөтөлбөрийн үнэлгээний арга нь оюутны сурах үйл ажиллагааг сайжруулах хөгжүүлэх зорилгоор суралцах явцад нь хийдэг бол төгсгөлийн үнэлгээ дүгнэлт болон чанарын баталгаажуулалтын зорилгод төвлөрдөг гэж үздэг. Бид Нийгмийн эрүүл мэнд судлалч мэргэжилтний цогц чадамжийг үнэлэх зорилготой ажилласан. Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар гүйцэтгэсэн. Судалгаанд АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Нийгмийн эрүүл мэнд судлалч хөтөлбөрөөр суралцаж байгаа III-Ү дамжааны 74 оюутнууд, 39 багш нар, 2012-2021 онуудад уг хөтөлбөрөөр суралцаж төгссөн 74 төгсөгч, эрүүл мэндийн байгууллагууд болон мэргэжлийн хяналтын байгууллагад ажилладаг 84 удирдах ажилтнууд зэрэг нийт УБ хот ба хөдөө орон нутгийн 271 хүнийг судалгаанд хамруулсан. Сургалт үр дүнтэй сайн гэж судалгаанд оролцогч оюутнуудын 93.1%, төгсөгчдийн 91.8% нь дундаас дээш үнэлсэн байна. Хөтөлбөрийн агуулгыг хангалттай сайн гэж багш нарын 97.5% нь, сургалтын орчин шаардлагад нийцнэ гэж 92.1% нь дундаас дээш үнэлсэн байна. Сургалтын үйл ажиллагааг (сургалтын зохион байгуулалт, хичээл хоорондын уялдаа холбоо, багшийн заах арга зүй, оюутан мэдлэг, чадвараа бодитой үнэлүүлсэн, сургалтын орчин, ном сурах бичиг, оюутны ачаалал тохиромжтой) зэрэг үзүүлэлтээр үнэлэхдээ оюутнууд 86.7% харин төгсөгч нар 91.5% нь дундаас дээш буюу ликертийн 3-аас дээш оноогоор үнэлсэн байна.

Цогц чадамжийг үнэлсэн дүнг ликертийн оноогоор харуулахад дунджаар 93,2% дундаас дээш үнэлгээ өгсөн байна. НЭМ-ийн 8 цогц чадамжид өгсөн оноог төгсөгч, ажил олгогчийн хувьд харьцуулахад Үр ашигтай хамтрагч, харилцагч, Соёл ёс зүйг эрхэмлэгч, Олон нийтийн ажилтан нөлөөлөгч, Манлайлагч зэрэг ур чадваруудыг ажил олгогчид төгсөгчдөөс статистик ач холбогдол бүхий ялгаатай бага түвшинд үнэлсэн байна ($p>0.05$). Судалгаанд хамрагдсад болох одоо суралцаж буй оюутнууд, төгсөгчид, багш нар, удирдах ажилтнууд буюу ажил олгогчид нар нь нийгмийн эрүүл мэндийн судлалч сургалтын хөтөлбөрт сэтгэл хангалуун гэж үзэж байна.

Оршил

Үндэслэл: “Эрүүл мэндийн тухай хууль”-д Монгол улсын Эрүүл мэндийн салбарын эрүүл мэндийн тусламжийн тэргүүлэх чиглэлийг “НЭМ-ийн тусламж үйлчилгээ” хэмээн хуульчлан тусгасан. НЭМ-ийн тусламжийн үндсэн зорилго нь хүн амын дундах эрүүл мэндийг байдлыг гадаад орчин, нийгэмтэй холбон судлан тогтоох, үнэлэх, түүнд тулгуурлан бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, эрх зүйн орчны баталгааг хангах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулсан хэрэгжилтэнд нь хяналт, зохицуулалт, зөвлөмж удирдамжаар хангах гэсэн үндсэн зарчимд тулгуурлан хөгжиж байна.[1] 2014

онд боловсруулсан НЭМ-ийн мэргэжилтний цогц чадамжинд НЭМ-ийн мэргэжилтний эзэмшвэл зохих цогц чадамжийг "Нийгмийн эрүүл мэндийн шинжээч, судлаач, бодлого, хөтөлбөр боловсруулагч, төлөвлөгч, үр ашигтай хамтрагч, харилцагч, соёл, ёс зүйг эрхэмлэгч, олон нийтийн ажилтан, нөлөөлөгч, санхүүч, удирдагч, манлайлагч байна" хэмээн тодорхойлсон.[2]

Зорилго: Нийгмийн эрүүл мэнд судлалч мэргэжилтний цогц чадамжийг үнэлэх

Арга аргачлал: Судалгааг агшингийн судалгааны дескриптив загвараар гүйцэтгэсэн ба 2012-2021 оны хооронд АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэнд судлалч хөтөлбөрөөр хичээллэж байгаа III-Y дамжааны оюутан, багш нар, тус хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид, тэдний ажилладаг байгууллагуудын удирдах ажилтан нийт 271 хүнийг энгийн зорилтот түүвэрлэлтийн аргыг ашиглан судалгаанд хамруулсан. Судалгааны 4 бүлэг асуумжийг (оюутан, багш, төгсөгч, ажил олгогч) судлаач Д.Отгонбаярын (2010) "Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд" нэг сэдэвт бүтээлдээ боловсруулан ашигласан асуумжийг судлаачийн зөвшөөрөлтэйгээр авч уг судалгаанд ашигласан. Статистик боловсруулалтыг STATA программ хангамжаар шинжилгээ хийж сэтгэл ханамж, цогц чадамж, үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрийн дундаж утга, голч утга, хамгийн их, бага утгыг тооцож үзүүлэлт тус бүрээр ялгаатай байх таамаглалыг параметрийн бус тестээр шалгаж, p утга 0.05-аас бага байгаа тохиолдолд таамаглал үнэн магадтай байхаар тооцсон.

Үндсэн хэсэг:

Үр дүн: НЭМ судлалч мэргэжлээр суралцаж байгаа 3-5-р дамжааны 74 оюутан хамрагдсан ба 3-р дамжаанд суралцдаг 28.7% (n=21), 4-р дамжаанд суралцдаг 41.1% (n=30), 5-р дамжаанд суралцдаг 30.1% (n=22) байна. НЭМ судлалч хөтөлбөрт хичээл заадаг 39 багш оролцсон ба үндсэн мэргэжлийн хувьд 30.7% нь хүний их эмч 28.2% НЭМ судлалч/эрүүл ахуйч/тархвар судлаач, 41.1% бусад мэргэжлийн багш нар байна. Тус мэргэжлээр 2012 оноос хойш төгссөн 74 төгсөгчийг судалгаанд хамруулсан ба 62.1% нь Эрүүл ахуйч/тархвар судлаачаар, 14.8% нь НЭМ-ийн мэргэжилтнээр, 9.4% эрүүл ахуй халдвар хяналтын байцаагчаар, 8.1% нь эрдэм шинжилгээний ажилтан судлаачаар, 5.4% нь бусад мэргэжлээр ажиллаж байна. Судалгаанд ажил олгогчийн төлөөлөл болгож 84 удирдах ажилтныг судалгаанд хамруулсан.

НЭМ судлалч хөтөлбөрийн сургалт үр дүнтэй сайн гэж судалгаанд оролцогч оюутнуудын 93.1%, төгсөгчдийн 91.8% нь дундаас дээш үр дүнтэй гэж үнэлсэн байна.

Хүснэгт 1. Сургалтын үйл ажиллагааг үнэлсэн байдал (оюутан, төгсөгч)

Сургалт үр дүнтэй сайн Оноо	Оюутан		Төгсөгч	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
5 Санал бүрэн нийлнэ	11	15.07	14	18.9
4 Ихэнхдээ санал нийлнэ	32	43.84	37	50.0
3 Дунд зэрэг	25	34.25	17	22.9
2 Ихэнхдээ санал нийлэхгүй	4	5.48	6	8.1
1 Огт санал нийлэхгүй	1	1.37	0	0
Нийт	73	100	74	100

Сургалтын үйл ажиллагааг (сургалтын зохион байгуулалт, хичээл хоорондын уялдаа холбоо, багшийн заах арга зүй, оюутан мэдлэг, чадвараа бодитой үнэлүүлсэн, сургалтын орчин, ном сурах бичиг, оюутны ачаалал тохиромжтой) зэрэг үзүүлэлтээр үнэлэхэд оюутнуудын 86.7% харин төгсөгч нарын 91.5% нь дундаас дээш гэж үнэлсэн байна. Оюутны ачаалал тохиромжтой гэж үзсэн хариултыг дамжааны хувьд харьцуулахад 5-р дамжааны оюутнууд сургалтыг илүү үр дүнтэй гэж хариулсан боловч статистик ач холбогдолтой ялгаа ажиглагдсангүй ($p< 0.526$).

Хүснэгт 2. Оюутны ачаалал тохиромжтой эсэх (дамжаагаар)

Дамжаа	1	2	3	4	5	Нийт
3	0	1	6	8	6	21
	0	4,76	28,57	38,1	28,57	100
4	1	1	4	14	10	30
	3,33	3,33	13,33	46,67	33,33	100
5	0	0	8	10	4	22
	0	0	36,36	45,45	18,18	100
Нийт	1	2	18	32	20	73
	1,37	2,74	24,66	43,48	27,4	100
Fisher's exact = 0.526						

Хөтөлбөрийн агуулгыг хангалттай сайн гэж багш нарын 97.5% нь дундаас дээш үнэлсэн ба сургалтын орчин шаардлагад нийцнэ гэж 92.1% нь үзсэн байна. НЭМ судлалч мэргэжлээр төгсөгчдийн эзэмшсэн мэдлэг, чадвар ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг гүйцэтгэхэд хангалттай эсэхийг үнэлэхэд 79.4% нь дундаас дээш хангалттай гэж үнэлсэн байна. Багш нар сургалтын гол үйл ажиллагаануудыг ихэвчлэн 95% -аас дээш үнэлсэн боловч ном сурах бичгийн хангалт, хүртээмж, сургалтын орчин дээр 10,8-15% нь сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Хүснэгт 3. Сургалтын үйл ажиллагааг багш нар үнэлсэн байдал

	Зохион байгуулалт		Хөтөлбөрийн агуулга		Багшийн заах арга зүй		Сургалтын орчин		Оюутны идэвхи оролцоо		Ном сурах бичиг хангалттай		Гарын авлага хөтөч хангалттай	
	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%	тоо	%
5	13	34,2	10	25,6	14	36,9	7	18,5	6	15,8	3	8,1	4	10,8
4	18	47,3	27	69,4	21	55,2	14	36,8	17	44,7	14	45,9	16	43,2
3	5	13,2	1	2,5	2	5,3	14	36,8	14	36,9	11	29,7	13	35,1
2	2	5,3	1	2,5	1	2,6	2	5,3	1	2,6	4	10,8	4	10,8
1							1	2,6			2	5,4	0	0

Цогц чадамжийг үнэлсэн дүнг ликертийн оноогоор харуулахад дунджаар 93,2% дундаас дээш үнэлгээ өгсөн байна. НЭМ-ийн 8 цогц чадамжид өгсөн оноог төгсөгч, ажил олгогчийн хувьд харьцуулахад Үр ашигтай хамтрагч, харилцагч, Соёл ёс зүйг эрхэмлэгч, Олон нийтийн ажилтан нөлөөлөгч, Манлайлагч зэрэг ур чадваруудыг ажил олгогчид төгсөгчдөөс статистик ач холбогдол бүхий ялгаатай бага түвшинд үнэлсэн байна. ($p>0.05$)

Хүснэгт 4. НЭМ судлалч мэргэжилтний цогц чадамж (төгсөгч, ажил олгогч)

Үзүүлэлт	Төгсөгч		Ажил олгогч		Дундаж	Р утга
	Тоо	Хувь	Тоо	Хувь		
Оноо	**1.НЭМ-ийн шинжээч**					0.773
5	11	15.07	13	15.48	91.1%	
4	28	38.36	24	28.57		
3	28	38.36	39	46.43		
2	5	6.85	7	8.33		
1	1	1.37	1	1.19		

Оноо	**2.С**удлаач					0.118
5	18	24.32	14	16.67	92.7%	
4	32	43.24	30	35.71		
3	22	29.73	30	35.71		
2	1	1.35	8	9.52		
1	1	1.35	2	2.38		
Оноо	**3.Б**одлого боловсруулагч, төлөвлөгч					0.622
5	15	20.27	11	13.10	92.5%	
4	32	43.24	35	41.67		
3	23	31.08	30	35.71		
2	3	4.05	7	8.33		
1	1	1.35	1	1.19		
Оноо	**4.Y**р ашигтай хамтрагч, харилцагч					**0.010**
5	23	31.08	16	19.05	96.35%	
4	41	55.41	37	44.05		
3	9	12.16	26	30.95		
2	1	1.35	4	4.76		
1	0	0	1	1.19		
Оноо	**5.С**оёл ёс зүйг эрхэмлэгч					**0.010**
5	24	32.43	22	26.19	97%	
4	41	55.41	34	40.48		
3	7	9.46	25	29.76		
2	2	2.7	2	2.38		
1	0	0	1	1.19		
Оноо	**6.О**лон нийтийн ажилтан нөлөөлөгч					**0.028**
5	24	32.43	23	27.38	95.16%	
4	38	51.35	32	38.10		
3	11	14.86	22	26.19		
2	0	0	6	7.14		
1	1	1.35	1	1.19		
Оноо	**7.С**анхүүч, удирдагч					0.395
5	14	18.92	8	9.52	87.4%	
4	30	40.54	31	36.90		
3	22	29.73	33	39.29		
2	7	9.46	10	11.90		
1	1	1.35	2	2.38		
Оноо	**8.М**анлайлагч					**0.013**
5	19	26.03	17	20.24	93,9%	
4	38	52.05	32	38.10		
3	15	20.55	26	30.95		
2	0	0	8	9.52		
1	1	1.37	1	1.19		
					93,2%	

Хэлцэмж: Судлаач М.Өсөхбаяр нарын (2015) “АШУҮИС-ийн АУС-ийн Хүний их эмч бэлтгэх сургалтын нэгдмэл хөтөлбөрт өгөх сэтгэл ханамж” судалгааны дүнд судалгаанд хамрагдагсдын 63% хангалттай, 18.1% дунд зэрэг 18.9% нь хангалтгүй гэсэн үнэлгээ өгсөн байна.[4] Бидний судалгааны дүнд сургалтын үйл ажиллагааг үнэлэхэд оюутнууд 86.7%, төгсөгчид 91.5% нь дундаас дээш гэж үнэлсэн байна. Судлаач Д.Отгонбаяр нарын (2010) “Анагаах ухааны сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудлууд” судалгааны дүнд сургалтын нэгдмэл хөтөлбөрөөр суралцагсдын сэтгэл ханамжийн ерөнхий түвшин 90.8%, багш нарын 72.23%, төгсөгчдийн 94.1% сургалтын нэгдсэн хөтөлбөрт дундаас дээш хангалттай гэсэн үнэлгээг өгсөн байна.[3] Энэ нь бидний судалгааны дүнтэй ойролцоо буюу багш нар АШУҮИС-д багшлахдаа 97.4% сэтгэл ханамжтай, төгсөгчдийн 93.1% нь НЭМ судлалч хөтөлбөрөөр суралцсандаа сэтгэл ханамжтай гэж тус тус дүгнэсэн.

Дүгнэлт:

1. Нийгмийн эрүүл мэнд судлалч бакалаврын хөтөлбөрт өгсөн үнэлгээ нь оюутан, багш, төгсөгч, ажил олгогчийн сэтгэл ханамж 91.8%-97.5% байна.
2. Цогц чадамжийг үнэлсэн дүнг ликертийн оноогоор харуулахад дунджаар 93.2% нь дундаас дээш үнэлгээтэй буюу сэтгэл ханамж сайн байна.

Ном зүй:

1. *НЭМ судлалч баклаврын хөтөлбөр өөрийн үнэлгээний тайлан 2018 он (Х10-15)*
2. *Мэргэжилтний цогц чадамж, АШУҮИС, 2014он (Х 429-433)*
3. *Судлаач Д.Отгонбаяр «Анагаахын сургалтын нэгдмэл хөтөлбөрийн үнэлгээний зарим асуудалд» АУ-ны докторын зэрэг горилсон бүтээл. (Х 52-55)*
4. *Судлаач М.Өсөхбаяр нарын хүний их эмч бэлтгэх сургалтын нэгдмэл хөтөлбөрт өгөх төгсөгчдийн сэтгэл ханамжийг судасан судлагаа анагаах ухааны магистерийн ажил горилсон бүтээл, 2015 он (Х 4-5)*
5. *The Executive Council of the WFME (1998). International standards in Medical Education: assessment and accreditation of medical schools’ educational programmes. A WFME position paper. Medical Education. 32 (5) p 549-558*

Comprehensive competence of bachelor degree program In public health researchers

S.Myagmarchuluun[1], B.Yanjinlkham[2], D.Otgonbayar[3], L.Bayarmagnai[1], E.Erdenechimeg[1], D.Davaalkham[1], D.Amarsaikhan[1]
School of Public health, MNUMS[1]
Master student of Public health, MNUMS[2]
Division for Science and Technology, MNUMS[3]
Email: myagmarchuluun@mnums.edu.mn, Tel: 89004748

Keyword:

Public health specialist, comprehensive competence, program

Abstract

Formative assessment with emphasis on feedback has been linked to developmental purposes of assessment, whilst summative assessment is assumed to focus on judgemental and quality assurance purposes.

Thus, we aimed to assess the comprehensive competencies of professionals by evaluating the bachelor's program in School of Public health, MNUMS. The study was conducted by using a cross sectional study design. There were total of 271 people including 74 students of 3-5 course, 39 professors, 74 public health specialists and 84 administrative staffs, who are working at three level hospitals and professional inspection organizations from UB and some provinces.

Results: Majority of the current students showed satisfaction of good by 93.1% and regarding graduates is 91.8% as a good. According to faculty members satisfied 97.5% the training activities of the program as good and 92.1% rated the training environment as more than 3 points by likert score. According to current students satisfied 86.7% and graduates satisfied 91.5% the training activities of the program (training activities, subject coordination, teaching methodology, students' knowledge and skills are fairlly assessed, training environment, textbooks, student workload is appropriate) as more than 3 points by likert.

The average comprehensive competence score was 93.2%. Comparing 8 comprehensive competence of public health specialists as graduates and employers, employers rated the skills of effective partner, ethical specialist and leader at a statictically lower level than graduates ($p>0.05$)

Conclusion: According to participants (current students, regarding graduate, teachers and administrative staffs) satisfied on curriculum of public health researchers' program as a good.

Abstract

Evaluation of current status of video contents in MNUMS e-learning system

S.Gal-Erdene[1], B.Baljinnaym[1], G.Naransukh[1], M.Uzmee[1], Kh.Ser-Od[2], S.Khandmaa[1]
Division for faculty development and e-learning, MNUMS[1]
School of Public Health MNUMS[2]
E-mail: gal-erdene@mnums.edu.mn, Tel: 99076440

Keywords:

video lecture, video evaluation, learning management system

Mongolian national university of medical sciences has conducted its training through e-learning format during Covid 19 pandemic situations and 100 percent of the lecture content of the training was placed and used at (http://elearning.mnums.edu.mn/). This study is based on the fact that the format and technology of videos placed in the system during pandemic situation were different from each other. Aim of the study was to evaluate MNUMS e-learning system's video content with checklist and define the current condition. Total of 292 video materials from 23 general basic lessons in the first grade of medical basic course which were placed in MNUMS E-learning system (http://elearning.mnums.edu.mn) were included in the study. Videos were evaluated by MNUMS e-learning video content evaluation checklists including 20 closed and open-ended questions which were developed by Division for E-learning and faculty development and analyzed the data. In the study the lesson with the largest number of videos placed in the system consisted of 53 videos and the lesson with the least number of videos placed in the system consisted 4 videos. Among the video material types, 204 videos were lectures, 63 were seminars and practice classes, and 25 were additional study materials. The average size of the video material was 103.18 megabyte, and the average video material duration time was 22.25 minutes. In the lecture video material, 10.4% of them mentioned its subject name, 11.9% its year, 13.8% its contact information, 19.8% its conclusion, 23.1% its subject number and order, 32.5% its teacher information, 44.8% its school and department, 50.7% its general content, 64.2% its teacher name, and 96.3% of them mentioned its subject name. Teacher image was included in 56.5%, and school logo was in 27.3% of the video materials. 2.4% of the video materials were made absolutely good, do not need any editing, 65.1% of them do not need editing, 25% of them need somewhat editing but students can study them, 5.1% of them need editing, and 2.4% of them definitely need editing. In conclusion, there is no need to include variable information in lecture videos. About 70% of video materials lack source of the information. There is a need to re-make 7.5% of the video materials. The study indicates that long duration and poor quality of the videos lead to an increase in the number of system accesses.